# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/280 Булган сум

Тариаланчдын зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IX/63 дугаар "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөр батлах тухай тогтоолын 4.6.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/97 дугаар "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай" захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, тариаланчдын идэвх санаачилгыг өрнүүлэх, хаврын тариалалтын агро зөвлөмжийг хүргэх аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Булган суманд зохион байгуулсугай.

2.Дээрх зөвлөгөөнийг зохион байгуулах ажлыг хэсгийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3.Зөвлөгөөнд шаардагдах 6,600,000 (зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийг "Шинэ хөдөө" сэргэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх зөвлөгөөнийг чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010404

Sugar Ажил 2026 өдөр бүр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
А/280 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:
- Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
- Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
- Б.Баярбат (ХААН банкны захирал, зөвшилцсөнөөр)
- Б.Энхбаяр (Аймгийн Тариаланчдын холбооны гүйцэтгэх захирал, зөвшилцсөнөөр)
- Б.Мөнхбаатар (“СМ” телевизийн захирал)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
А/280 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| д/д | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төг) | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Хулдаасан хэвлэл | м2 | 5*3 | 20,000 | 300,000 |
| 2 | Баннер тогтоох материал, микрофон зай | төг | 1 | 150,000 | 150,000 |
| 3 | Заалны түрээс | өдөр | 1 | 1,000,000 | 1,000,000 |
| 4 | Хүндэтгэл үзүүлэх (Оюунсуртал гавьяат) | төг | 1 | 1,000,000 | 1,000,000 |
| 5 | Багшийн сургалтын хөлс | хүн | 5 | 150,000 | 750,000 |
| 6 | Хоолны зардал | хүн | 250 | 13,600 | 3,400,000 |
| **Бүгд** | | | | | **6,600,000** |

--o00o--